



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 01

Ховд

Г Улсын сайн малчнаар тодорхойлох тухай Г


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын сайн малчин” шалгаруулах журам, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Улсын сайн малчин” шалгаруулах журмын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан Цэцэг сумын Хажинга багийн малчин Авид овогтой Амархүү, Буянт сумын Цагаанбургас багийн малчин Должинсүрэн овогтой Отгонням, Үенч сумын Жаргалан багийн малчин Хинат овогтой Бербай, Мөст сумын Баянхайрхан багийн малчин Жавзан овогтой Төмөрөө, Дарви сумын Баянбулаг багийн малчин Рэнцэндорж овогтой Цэрэндорж, нарыг “Улсын сайн малчин” цол, шагнал олгуулахаар тодорхойлсугай

2.“Улсын сайн малчин”-аар тодорхойлогдож байгаа дээрх малчдын тодорхойлолт, холбогдох баталгаажсан материалыг Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга / Д.Цэвээнравдан /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 02

Ховд

Улсын тэргүүний тариаланчаар
тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын тэргүүний тариаланч” шалгаруулах журам, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- “Улсын тэргүүний тариаланч” шалгаруулах журмын шалгуур үзүүлэлтийг бүрэн биелүүлсэн Буянт сумын Норжинхайрхан багийн тариаланч Идэш овогтой Батсүх, Буянт сумын Норжинхайрхан багийн тариаланч Цагаан овогтой Шинэбаяр, Жаргалант сумын Буянт багийн тариаланч Чулуунхүү овогтой Дэмбэрэл нарыг “Улсын тэргүүний тариаланч” цол, шагнал олгуулахаар тодорхойлсугай.
- “Улсын тэргүүний тариаланч”-аар тодорхойлогдож байгаа тариаланчдын тодорхойлолт, холбогдох баталгаажсан материалыг Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 03

Ховд

Г Алтан төлийн ээнээр тодорхойлох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Алтан төлийн эзэн” шалгаруулах журамд заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан Мянгад сумын Цагаанбулан багийн малчин Бямба овогтой Хаш-Эрдэнэ, Мөнххайрхан сумын Хаг багийн малчин Чоймбол овогтой Оюун нарыг “Алтан төлийн эзэн” цол, шагнал олгуулахаар тодорхойлсугай.

2.“Алтан төлийн эзэн”-ээр тодорхойлогдож байгаа дээрх малчдын тодорхойлолт, холбогдох баталгаажсан материалыг Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон МҮОНТ-д хүргүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 05

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга / Н.Бөхболд /-д үүрэг болгосугай.





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 07

Ховд

Аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны "Аймгийн шагналын журам" батлах тухай 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|---------------------------|--|
| 1. Доржсүрэн Виктор | - Жаргалант сумын иргэн |
| 2. Доржготов Бямбадорж | - Жаргалант сумын иргэн |
| 3. Нямаа Гантөмөр | - Ховд АЗЗА ХК-д жолооч |
| 4. Гунгаа Хүүхнээ | - Ховд АЗЗА ХК-ны жолооч |
| 5. Отгоо Уламбаяр | - Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүхэд үйлчлэгч |
| 6. Эрдэнэбаатар Дэлгэрмаа | - Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүхэд үйлчлэгч |

ХУРАЛ ДАРГАЛАГЧ Б.БОЛД





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 08

Ховд

Хуралдаан зарлах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "б", "д", "к" заалт, 22 дугаар зүйлийн 22.1.1, 23 дугаар зүйлийн 23.3, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 28.3 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Ховд хотод хуралдуулж, дараахь асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1. Орон нутгийн 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай илтгэл

1.2. Зарим газар нутгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтанд авах тухай илтгэл

1.3. Аймгийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай илтгэл

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 11

Ховд

Гурван сая дахь иргэний чацуутанг шагнах,
алдаршуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 400 дугаар тогтоолын 2 болон 4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын гурван сая дахь иргэнтэй хамгийн ойр мэндэлсэн, чацуутан Ховд сумын харьяат Серик овогтой Алтынбахад 70,0 сая /далан/ хүртэл төгрөгийн үнэ бүхий орон сууц буюу түүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгохыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д зөвшөөрсүгэй.
2. Ховд аймгийн Ховд сумын иргэн Серик овогтой Алтанбахыг Монгол улсын 3 сая дахь иргэний чацуутанаар шалгарсаныг нийтэд алдаршуулах, сурталчлах ажлыг орон нутагт зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/, Ховд сумын Засаг дарга /Ч.Ерболат/ нарт даалгаж, сумын ИТХ-ын дарга /Х.Тилеухан/-д зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 12

Ховд

Цахим сүлжээ түгээх үйл
ажиллагааны тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.1 дахь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.3-ын "м", Харилцаа холбооны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон "Цахим Ховд" интернэтийн цахим үйлчилгээний менежментийн багийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэстэй хамтран шалгаруулж гэрээ байгуулан ажиллахыг аймгийн ИТХ-ын Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Б.Баттүвшин/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 13

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Алтан гадас одон”-гоор

- | | |
|--------------------|--|
| 1. Сэтэв Дорж | - Ховд Их сургуулийн Биологийн тэнхмийн багш |
| 2. Шатарбал Цэлээ | - Цэцэг сумын ахмад настан |
| 3. Мөнхбаяр Баатар | - Хөгжимт драмын театрын дарга |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

- | | |
|-------------------|---|
| 1. Найдан Туяа | - Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн багш |
| 2. Хульдаа Батсүх | - Жаргалант сумын “Бүрэн хайрхан” ХХК-ний захирал |
| 3. Нанжaa Дүрвээ | - Алтай сумын Тахилт багийн иргэн |

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 14

Ховд

Г Аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр
шагнах тухай Г


Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны "Аймгийн шагналын журам" батлах тухай 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|--------------------------|---|
| 1. Самдан Коля | - Дарви сумын Мөрөн багийн ахмад настан |
| 2. Дамдинжав Баасандорж | - Дарви сумын Мөнгөн аяга багийн ахмад настан |
| 3. Батаа Амартувшин | - Дарви сумын Булаг багийн ахмад настан |
| 4. Самдан Цэнд | - Дарви сумын Баянбулаг багийн ахмад настан |
| 5. Даваа Цэдэнпил | - Дарви сумын Дэлгэр багийн ахмад настан |
| 6. Санж Төрбат | - Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн ахмад
настан |
| 7. Баянаа Пуудай | - Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн ахмад настан |
| 8. Шаравжамц Баттулга | - Эрдэнэбүрэн сумын Намарзан багийн ахмад
настан |
| 9. Доржсүрэн Лхагвасүрэн | - Эрдэнэбүрэн сумын хүн эмнэлгийн асрагч |
| 10. Түмэннасан Хашбаатар | - Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин |

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 15

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.1, 20.1.9, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2015 онд нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдөр, сум, байгууллагын ой, спорт, урлагийн арга хэмжээ, сургалт семинар, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Нийтээр тэмдэглэх баяр, ой, тэмдэглэлт өдрүүдийг салбар байгууллагын хэмжээнд бүтээн байгуулалтын ажил өрнүүлж ёспол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх, урлаг спорт, соёл урлагийн арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг сум, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Нэгдсэн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн явцын тухай хагас, бүтэн жилээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/, Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Батмөнх/ нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА *Баяр* Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 17

Ховд

Г Журам батлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-ийн 20.1.14, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-ийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд, аймгийн Засаг даргын 2015 оны 1/30 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн нутаг дэвсгэрт “Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Сумын нутаг дэвсгэрт хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого, хөтөлбөрийг иргэдийн оролцоотой боловсруулан баталж, Засгийн газраас тогтоосон аргачлалын дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоож мөрдүүлж ажиллахыг сумдын ИТХ-ын дарга нарт зөвлөсүгэй.

Гурав. Аймаг сумдын Засаг дарга нарт үүрэг болгох нь:

3.1. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцож ажиллах;

3.2. Олон нийтэд хог хаягдлын тухай мэдээлэл сурталчилгааг өргөтгөн, түүнийг цэвэрлэх, зайлзуулах ажилд иргэд, өмчийн бүх хэвшлийн байгууллагуудыг татан оролцуулах, хог хаягдлын улмаас байгаль экологид учирсан хохирлыг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж байх;

3.3. Хог хаягдлын хууль тогтоомжуудын хэрэгжилтэнд хяналт тавих мэргэжлийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг тогтмолжуулан холбогдох хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг эрс дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах;

3.4. Хог хаягдлын хураамжийг төсөвт төвлөрүүлэхэд холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдааг хангахаар удирдлага зохион байгуулалт, зохицуулалтыг тухай бүр хийж, биелэлтэнд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах;

3.5. Хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулан зохих журмын дагуу батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах;

Дөрөв. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулж үр дүнг хагас, бүтэн жилээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д даалгасугай.





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 13 сарын 18 өдөр

Дугаар 18

Ховд

Г Журам батлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1."Аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д үүрэг болгосугай.
3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Ховд аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журмыг батлах тухай " 2009 оны 99 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 19

Ховд

Г Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай Г

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол Улсын Гавьяат багш цол”-оор

- | | |
|-----------------|--|
| 1. Егнэн Пунцаг | - Жаргалант сумын 12 жилийн сургуулийн
ахмад багш |
|-----------------|--|

“Монгол Улсын Гавьяат мал зүйч цол”-оор

- | | |
|--------------------|--------------------------------------|
| 1. Райхан Хасымхан | -“Без казына” мал эмнэлгийн мал зүйч |
|--------------------|--------------------------------------|

“Худалдааны Гавьяат ажилтан цол”-оор

- | | |
|--------------------------|----------------------------|
| 1. Пэрэнлэй Тогтохбаатар | - Ховд Тур ХХК-ний захирал |
|--------------------------|----------------------------|

“Сүхбаатрын одон” - гоор

- | | |
|----------------------|---|
| 1. Баянхүү Бямбажамц | - Жаргалант сумын Жаргалан багийн
ахмад настан |
|----------------------|---|

“Хөдөлмөрийн Гавьяаны улаан тугийн одон”-гоор

- | | |
|---------------------|---|
| 1. Замба Баасандорж | - Дөргөн сумын ахмадын хорооны дарга |
| 2. Магсар Нямжав | - Мэдээлэл холбооны сүлжээ Төрийн
өмчит ХК-ний ахмад ажилтан |
| 3. Дамбий Уртнасан | - Жаргалант сумын Магсаржав багийн
ахмад настан |

- | | |
|---|---|
| 4. Ядамсүрэн Даваажав
5. Рэнцэндаваа Цэндсүрэн
6. Чимгээ Пүрэвдорж
7. Табылбай Тилеухан
8. Чилхаа Хархүү | - Жаргалант сумын Магсаржав багийн ахмад настан
- Чандмань сумын Тахилт багийн ахмад настан
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Ховд сумын Улаанбуураа багийн ногоочин
- Мөст сумын Соёлын төвийн эрхлэгч

"Алтан гадас одон"-гоор |
| 1. Батзундуй Дарьсүрэн
2. Дарьхүү Дашгэрэл
3. Дүгэrsүрэн Цэнддаш
4. Сундуижав Хишгээ
5. Должин Даваа
6. Сэргамба Дамдиндорж
7. Самдан Содмоо
8. Данзан Эрдэнэцогт
9. Дашравдан Баатар
10. Пэрэнлэй Гонгоржав
11. Гүр Авир
12. Намжил Чоймпиг
13. Намрал Баасай
14. Батмөнх Дагвасүрэн
15. Тогмид Магсар
16. Хорлоо Нанжаасүрэн
17. Почоон Баатар
18. Маньбадар Даваа | - Чандмань сумын Тахилт багийн ахмад настан
- Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК-ний диспетчер
- Жаргалант сумын ахмад настан
- БОЭТ-ийн чих хамар хоолойн эмч
- Эм хангамж ХХК-ний ахмад ажилтан
- Хаш өргөө ХХК-ний ахмад ажилтан
- Дуут сумын Босго багийн ахмад настан
- Жаргалант сумын Цамбагарав багийн ахмад настан
- Жаргалант сумын Тахилт багийн иргэн
- Мянгад сумын Баянбулаг багийн ахмад настан
- Чандмань сумын Тахилт багийн ахмад настан
- Манхан сумын Төгрөг багийн ахмад настан
- Манхан сумын Тахилт багийн малчин
- Манхан сумын Тахилт багийн малчин
- Манхан сумын Зэрэг гол багийн малчин
- Алтай сумын ахмад настан
- Жаргалант сумын Хайрхан багийн ахмад настан
- Жаргалант сумын Хайрхан багийн ахмад настан |

- | | |
|---|--|
| 19. Чулуунбат Пүрэвсүрэн
20. Схак Гайв
21. Гочоо Цэдэн
22. Цогт-Очир Лхагвасүрэн
23. Түвшинжаргал Цогтоо

24. Хяргас Буянхүү
25. Ботгон Цэвээн | - Жаргалант сумын Буянт багийн ирггэн
- Жаргалант сумын Рашаант багийн иргэн
- Жаргалант сумын Магсаржав багийн иргэн
- Алтай сумын ЕБС-ийн химиин багш
- Мянгад сумын Чацарганат багийн ахмад настан

- Жаргалант сумын Тахилт багийн иргэн
- Жаргалант сумын Тахилт багийн ахмад настан |
|---|--|

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

- | | |
|---|--|
| 1. Ойдов Нанзаддорж
2. Баярнасан Бат-Очир

3. Гүрсэд Чойжилжав

4. Нанзад Сэнгэдорж

5. Хасым Өнөрхан

6. Хавдал Дөрбетхан

7. Таванзуу Бямбасүрэн

8. Бадарч Халтар

9. Ноосой Далай

10. Лхамсүрэн Надмид

11. Шакей Дүйсенбай

12. Хандсүрэн Батсүх

13. Намнан Наранцэцэг

14. Цэнд Санжмятав

15. Намнан Занданхүү

16. Нохойжав Балжир | - Мянгад сумын Чацарганат багийн малчин
- Булган сумын ахмад настан

- Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн ахмад настан
- Жаргалант сумын Буянт багийн ахмад настан
- Ховд сумын ЗДТГ-ын дарга
- Ховд сумын ЗДТГ-ын МЭҮТ-ийн мэргэжилтэн
- Алтай сумын ЕБС-ийн бага ангийн багш
- Манхан сумын Тахилт багийн ахмад настан
- Манхан сумын Төгрөг багийн ахмад настан
- Ховд сумын Баруун салаа багийн ахмад настан
- Ховд сумын Цагаанбургас багийн малчин
- Жаргалант сумын Рашаант багийн ахмад настан
- Манхан сумын Зэрэг гол багийн малчин
- Манхан сумын Зэрэг гол багийн малчин
- Манхан сумын Зэрэг гол багийн малчин
- Дуут сумын Босго багийн малчин |
|---|--|

- | | |
|----------------------|---|
| 17. Гиваа Баянмөнх | - Чандмань сумын Тахилт багийн малчин |
| 18. Отгон Дарьжав | - Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн улсын байцаагч |
| 19. Чойрог Цогтоо | - Дуут сумын Босго багийн ахмад настан |
| 20. Хандаа Батчулуун | - Жаргалант сумын Хайрхан багийн иргэн |
| 21. Мешел Хадай | - Ховд сумын Дунд ус багийн ахмад настан |
| 22. Шотай Нуриман | - Ховд сумын Дунд ус багийн ахмад настан |
| 23. Хунияз Жангавыл | - Ховд сумын Цагаанбургас багийн ахмад настан |
| 24. Дорж Хушигт | - Дөргөн сумын Аргалант багийн ахмад настан |
| 25. Шагдаржав Дашням | - Чандмань сумын Урд гол багийн ахмад настан |
| 26. Бэгз Дэмчиг | - Жаргалант сумын Тахилт багийн ахмад настан |
| 27. Гэлэг Хонгороо | - Жаргалант сумын Алагтолгой багийн ахмад настан |
| 28. Дүүрэн Дагва | - Чандмань сумын Тахилт багийн ахмад настан |





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛӨГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 20

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлөгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам” батлах тухай 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|--------------------------|---|
| 1. Авий Жилхбай | - Жаргалант сумын Наран багийн иргэн |
| 2. Көвеш Авилбай | - Жаргалант сумын Рашаант багийн иргэн |
| 3. Жыгышбай Төхөгөн | - Жаргалант сумын Рашаант багийн иргэн |
| 4. Дамдин Дэлгэр | - Жаргалант сумын Хайрхан багийн ахмад настан |
| 5. Поочоон Баатар | - Жаргалант сумын Хайрхан багийн ахмад настан |
| 6. Самданноров Боорцогоо | - Эрч – хүч ОНӨААТҮГ-т зам талбайн үйлчлэгч |
| 7. Сүхбаатар Батмөнх | - Эрч – хүч ОНӨААТҮГ-т жолооч |
| 8. Даваа Мөнхжаргал | - Худалдаа бэлтгэлийн газар эдийн засагч |
| 9. Цэрэвжав Сүнжидмаа | - Хадгаламж банкинд эдийн засагч |
| 10. Нанзад Сэнгэдорж | - Жаргалант сумын Буюнт багийн ахмад настан |
| 11. Жаанай Дэнсмаа | - Геологийн Алтай нэгдэлд тогооч |
| 12. Амет Ахмед | - Жаргалант сумын Наран багийн иргэн |
| 13. Сангаа Отгонбаяр | - Үенч сумын цэцэрлэгийн эрхлэгч |
| 14. Мягмар Цэнгэлмаа | - Үенч сумын ЗДТГ-ын нярав |
| 15. Бөхчулун Бурмаа | - Үенч сумын Соёлын төвийн эрхлэгч |
| 16. Дамдин Нямхүү | - Жаргалант сумын Жаргалан багийн ахмад
настан |

- | | |
|--------------------------|--|
| 17. Жамба Цэвээндолгор | - Жаргалант сумын бугат багийн ахмад настан |
| 18. Зугдар Цэрэнжав | - Жаргалант сумын баатархайрхан багийн ахмад настан |
| 19. Именхан Нургызар | - Буянт сумын Норжинхайрхан багийн иргэн |
| 20. Буяントогтох Мөнгөн | - Жаргалант сумын Алагтолгой багийн ахмад настан |
| 21. Пүрэвдаш Цэрэн-Очир | - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн жолооч |
| 22. Бөхчулуун Бямба-Очир | - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн жолооч |
| 23. Сундууйжав Алтансүх | - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ар талын дарга |
| 24. Ширчин Энхтөр | - Ховд сумын Баруун салаа багийн малчин |
| 25. Сүхбаатар Ганбаатар | - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн соёл хүмүүжлийн дарга |
| 26. Даваа Зулбадрах | - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн гол тогооны дарга |
| 27. Мухамед Бузабай | - Жаргалант сумын Рашаант багийн иргэн |
| 28. Хатабай Кармен | - Жаргалант сумын Цамбагарав багийн иргэн |
| 29. Аххожа Карим | - Жаргалант сумын Рашаант багийн иргэн |

